

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 7 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР
/ДАВАА ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-9
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-12
	1.Батлагдсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга танилцуулах	10-12
	2.Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	12-28
	3.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	29-53
	4.Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	53-62
	5.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос 2020.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	62-66

Хураангуй тэмдэглэл

Хоёр.Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжлийн үндэсний төвийн Ажлын албаны дарга С.Тэнгис “Их хуралдай” танхимаас, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл нар цахимаар тус тус оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга О.Номинчимэг, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар “Их хуралдай” танхимаас, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар цахимаар тус тус танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, О.Цогтгэрэл, Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Ё.Баатарбилэг, Г.Амартүвшин нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар “Их хуралдай” танхимаас, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нар цахимаар тус тус хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Х.Ганхуяг нар “Их хуралдай” танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан цахимаар тус тус үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 19

Бүгд: 63

69.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 15 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Ингээд дараагийн асуудалд орно. **Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Нямбаатар сайдыг индэрт урьж байна.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслийн талаар та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг Улсын Их Хурал 2011 онд баталсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх. Хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, Улсыг батлан хамгаалах, Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж заасан.

Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Үндсэн хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй гэж өөрсдөө хариулсан билээ. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1-д цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж төрийн үйлчилгээг шуурхай хариуцлагатай хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэнэ гэж.

4.1.1-д төрийн байгууллагын мэдээллийг иргэн аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлнэ гэж 4.1.8-д төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж иргэд олон нийтийн оролцоог хангана гэж мөн 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа-2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3 дахь заалтын 1 дүгээр үе шат 2021-2030 оны хооронд хэрэгжих үе шатын 4-т төрийн байгууллага хоорондын төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч үйлчилгээний үр дүн сайжирна гэж тус тус заасан байна. Түүнчлэн Улсын Их Хурал 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.2.3-т хуулиар зөвшөөрсөн, өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах ашиглах, бусад шилжүүлэхийг хориглоно гэж.

3.6.3.3-т төрийн өргөдөл мэдээллийг ангилж, үнэ цэнийг тогтоох бүртгэх, хадгалах, дамжуулах, шилжүүлэх, хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгож мөрдөнө гэж. 3.6.4.1-т хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах. Мэдээллийн дэд бүтэц түүний бүрдэл хэсэг үйлчилгээнд чөлөөтэй хангах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана гэж Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2.1.7-д Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн хяналт, иргэнийн нийгмийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэн идэвх санаачилгыг нэмэгдүүлэн идэвх санаачилгыг дэмжих гэж 2.1.8-д иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах гэж.

3.1.3-т ил тод нээлттэй байх зарчим, хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах. Төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод нээлттэй байх, иргэн хуулийн этгээд хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах, нөхцөл боломжийг бүрдүүлнэ гэж.

4.1.1.9-д төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж мэдээлэл солилцох боломжийг сайжруулах гэж Улсын Их Хурал 2018 оны Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 54 дүгээр тогтоолын 2-т төрийн мэдээлэл солилцох түүний аюулгүй байдлыг хангах, өгөгдөл хамгаалах, цахим засгийг бэхжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчинг боловсронгуй болгохтой холбоотой арга хэмжээг танилцуулах гэж тус тус тусгажээ.

Мэдээллийн ил тод байдлын ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн байгууллагын үйл ажиллагаа хүний нөөцийн мэдээллийг ил тод байлгах асуудлыг Шилэн дансны тухай хуулиар төрийн байгууллагуудын төсөв Улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах тэдгээртэй холбоотой мэдээллийг ил тод нээлттэй байх харилцааг зохицуулсан. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах тухай хууль нь дээр дурдсан хүрээнд мэдээллийг ил тод нээлттэй хүргэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн хэдий ч хэрэгжилтийн хувьд учир дутагдалтай буюу хуулийг агуулгын хувьд бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжгүй байна гэсэн дүгнэлтүүд гарсаар байна.

Ил тод байх мэдээллийн талаар хангалттай зохицуулалтгүйгээс төрийн байгууллагууд нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг албаны нууцад хамааруулан тогтоох боломжтой байгаа нь иргэний Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон мэдээлэл авах эрх хөндөгдөхөд хүрч байна.

Мөн ил тод мэдээллийн болон нээлттэй өгөгдлийн сан бий болгож улмаар иргэн хуулийн этгээд төрөөс бий болгосон нээлттэй өгөгдлийг өөрийн бизнес, үйлдвэрлэл, техник технологи, мэдлэгийг өргөжүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээ шинээр бий болгохдоо ашиглах боломжийг нээх шаардлага мэдээллийн технологийн салбарын өнөөгийн хөгжлийн түвшин дэлхий нийтийн жишиг хандлагын дагуу урган гарч байна. Төрийн байгууллага цуглуулж боловсруулж ашиглаж байгаа мэдээлэлд суурилсан төрийн үйлчилгээг иргэн хуулийн этгээдэд

хүртээмжтэй шуурхай хүргэх, төрийн байгууллагууд хоорондоо цахимаар мэдээлэл солилцох эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага бий болсон. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас төрийн цахим харилцааг өргөжүүлэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд тодорхой шийдвэрүүд гаргаж томоохон хөтөлбөр, төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний үр дүнд төрийн байгууллагууд өөр хоорондоо болон иргэн хуулийн этгээдтэй технологийн болон тусламжтайгаар үр ашигтай харилцах үйлчилгээгээ хангах цахим орчны дэд бүтэц, техник, технологийн суурь, дундын нөөцийг алхам алхмаар бүрдүүлж байна. Цахим орчны дэд бүтэц техник, технологийн суурь, дундын нөөц бүрдэж буй энэ үед төрийн байгууллагууд харилцан уялдаатай ажиллаж үүндээ тулгуурлан аливаа мэдээлэл этгээдэд мэдээлэл үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх, өөр хоорондоо мэдээлэл дамжуулах хуулийн хүрээнд мэдээлэл эрэн хайх, олж авах бүрдүүлэхтэй холбоотой харилцааг хуульчлах шаардлагатай байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахимжилт эрчимжиж, технологи нэвтрүүлэх ажил Засгийн газрын тогтоолоор хэрэгжиж ахицтай байгаа ч хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа сул, мэдээллийн технологийн сонголт хоорондын нийцэл, санхүү эдийн засгийн үр ашгийн байдлыг үнэлж дүгнэх болон мэдээллийн сангийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх үйл ажиллагаа хийгдэхгүй байгаа нь хууль, эрх зүйн орчин дутагдалтай байгаатай холбоотой юм. Монгол Улсад 1996 онд интернэтийн үйлчилгээ, интернэт банкны үйлчилгээ 2002 онд тус тус нэвтэрч төрийн болон бизнесийн олон үйлчилгээ онлайн цахим хэлбэрээр хийгдэхээр болсон. 2019 оны эцсийн байдлаар гар утас хэрэглэгчдийн тоо 4 сая 360 мянга, түүний дотор ухаалаг гар утас хэрэглэгчийн тоо 3.1 саяд хүрч үүрэн холбооны 4 дүгээр үеийн технологи нь нийт 360 гаруй сум суурин газруудыг хамаараад байгаа нь иргэд хуулийн этгээдийн зүгээс төрийн үйлчилгээ мэдээллийг хүндрэл зардал багатайгаар орон зай цаг хугацаанаас үл хамааран авах эрэлт хэрэгцээг бий болгож байна.

Монгол Улсын Засгийн газар 2018 оны 259 дүгээр тогтоолоор баталсан цахим хэлбэрээр шилжүүлж болох 496 үйлчилгээний 320 буюу 64 хувь нь баримт бичиг лавлагаа мэдээллийн бүрдэл шаарддаг бөгөөд тус баримт бичиг лавлагаа мэдээлэл нь төрийн бусад байгууллагаас олгогддог байна. Мөн үйлчилгээний нэгдсэн системээс гардаг цахим баримт бичгийг байгууллагууд хүлээн зөвшөөрөхгүй нотлох баримт, шүүх нотлох баримтаар үнэлэхгүй байх зэрэг асуудал гарч байгаа нь иргэдийг ихээхэн бухимдуулж, хуульчдын дунд маргаан, эргэлзээтэй байдлыг үүсгэж байна.

Хуулийн төслийн шинэчилсэн найруулга хэлбэрээр нийтийн мэдээллийн тухай хууль нэртэйгээр боловсруулж байгаа бөгөөд дээр дурдсан хэрэгцээ шаардлагад үндэслэн дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

1.Нийтийн мэдээллийн буюу төрд байгаа мэдээллийг нээлттэй хязгаарлалттай, хаалттай гэж ангилсан бөгөөд хаалттай мэдээлэл нь төрийн нууц болон хуулиар хаалттай гэж тогтоосон мэдээллийг, хязгаарлалттай мэдээлэл гэж хандах ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон бөгөөд хүн хуулийн этгээдийн зөвшөөрлийн үндсэн дээр хандаж ашиглаж болох мэдээлэл болон албаны нууцад хамаарах мэдээллийг ойлгохоор тусгалаа. Нээлттэй байх мэдээллийн жагсаалтыг жагсаалт байдлаар тодорхой тусгахыг зорьж одоогийн мөрдөж байгаа хуульд заасан нээлттэй ил тод байдлыг нэмэгдүүлээд тухайлбал тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл, мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа оюуны өмчийн эрх,

хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт түүнд өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл. Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн ашиг алдагдлын тайлан, удирдах зөвлөл хяналтын зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, гишүүд болон гүйцэтгэх удирдлагын овог нэр, авч байгаа цалин урамшууллын дүн, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хуулийн этгээд бусад нэгдсэн төсөв болон үндэсний баялгийн санд оруулж байгаа татвар, хөрөнгийн хэмжээ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хувь хүн хуулийн этгээдэд ашиглуулах шилжүүлэх хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүний ашиглалтаас гарах, ашиглалтаас гаргаснаас олсон орлогын талаарх мэдээлэл, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ, барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт. Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ байгуулсан гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал, улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандив, зүй ёсны монополь давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн талаарх мэдээлэл хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, өмчлөгчийн талаарх мэдээлэл. Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн талаарх мэдээлэл, нэвтрэх ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл. Мэдээллийн хариуцагчийн явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ ашиглаж байгаа техник, технологийн хүн ам, амьтны эрүүл мэнд байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл, хуульд заасан бусад жишээлбэл далай ашиглах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэл гэх мэт мэдээллүүд.

3.Эдийн засаг бизнесийг дэмжих судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй өгөгдөл бий болгох түүний нөхцөл, журам нээлттэй өгөгдлийг төлбөртэй болон төлбөргүйгээр ашиглуулахтай холбогдсон зохицуулалтыг тусгалаа.

4.Мэдээлэл хариуцагч нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүй, хуулийн этгээд хууль гэрээний үндсэн дээр төрийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд олон нийтийн радио, телевиз, Улсын дээд шүүхэд бүртгэлтэй нам зэрэг байгууллагууд байхаар тусгалаа.

5.Төрийн үйл ажиллагааг цахимаар явуулах иргэн хуулийн этгээдэд цахимаар үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага хоорондоо болон иргэн хуулийн этгээдтэй цахимаар харилцахад шаардлагатай нийтийн мэдээллийн дэд бүтэц, үндсэн хур систем болон дэмжих систем төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд эдгээр системийг ашиглан иргэн хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж болох талаар мөн мэдээллийн сүлжээ, мэдээллийн сангийн талаарх зохицуулалтыг тусгалаа.

6.Төрийн үйл ажиллагаа цахимжихтай холбоотойгоор төрөөс үйлчилгээ үзүүлэхдээ нийтийн мэдээллийн системээс олж авах мэдээлэл солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх. Төрийн байгууллага албан тушаалтан албан харилцаандаа албаны цахим хуудас, шуудан мэдээллийн систем ашиглах иргэн хуулийн этгээд улсын бүртгэлийн дугаараар цахим шуудангийн хаяг үүсгэхтэй холбоотой зохицуулалтыг тусган боловсрууллаа.

Нээлттэй өгөгдлийн тусламжтайгаар иргэн, хуулийн этгээд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ мэдлэг өргөжүүлэх боломжууд ч нээгдэхээр байгаа.

Нээлттэй мэдээллийн тухай хуулийн үзэл баримтлалыг хэлэлцэн баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын эрхэм гишүүн Лхагвын Мөнхбаатар танилцуулна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан зорилтыг хангах, төрийн байгууллагад цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа мэдээлэлд суурилан төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүртээмжтэй, шуурхай, хялбар байдлаар хүргэх, төрийн байгууллагууд хоорондоо цахимаар мэдээлэл солилцох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр газар эзэмших, ашиглах эрхийн талаарх мэдээлэл нийтэд ил тод бус байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Цахим хөгжлийн үндэсний хороог байгуулах шаардлагатай эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг татвар төлөгчийн мөнгөөр санхүүжиж байгаа төрийн байгууллагын мэдээлэл нууц мэдээлэлд багтсан шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар нийтийн мэдээлэл хариуцагч этгээдэд төрийн бус байгууллага болон хувьцаат компани хамаарах эсэх, түүнчлэн хаалттай мэдээллийн жагсаалтыг хуульчлах нь хир оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан Улсын Их Хурлын үйл ажиллагааны нууцыг хуулиар хэрхэн зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгайлан зохицуулсан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар мэдээллийг зүй бусаар ашиглахтай тэмцэх нь ардчиллын үндсэн зарчим болох, түүнчлэн төрийн байгууллагын хүний нөөцийн талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй байх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт удааширч байгаа шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төслийг Төрийн болон албаны нууцын тухай хуультай уялдуулан хэлэлцэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн мэдээлэл алдагдаж байгаа талаар санал хэлсэн болно.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы

нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар асуултад хариулна. Ажлын хэсгийг энэ дашрамд танилцуулъя бэлдэж байх хооронд. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Барсүрэнгийн Баасандорж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Пүрэвжавын Сайнзориг нар цахимаар оролцож байна. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээллийн технологийн газрын дарга Даваажавын Ган-Эрдэнэ цахимаар оролцож байна. Мөн Батцэнгэлийн Болор-Эрдэнэ Харилцаа холбоо мэдээллийн технологийн газрын дарга цахимаар оролцож байна. Сүхээгийн Тэнгис Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга. Тэнгис байна уу. Биечлэн оролцож байна. Бадамдоржийн Бэлэгдэмбэрэл Харилцаа холбоо мэдээллийн технологийн газрын мэдээллийн технологийн бодлогын зохицуулалтын газрын дарга, Жаргалсайханы Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн нар оролцож байна.

Одоо Хишгээгийн Нямбаатар сайд асуултад хариулна. Лхагвын Мөнхбаатар гишүүн мэдээлэл хийлээ. Одоо хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Амартүвшин гишүүнээр тасаллаа. Цахимаар нэг гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг асуулт асууна.

М.Оюунчимэг: Өдрийн мэнд хүргэе. Энэ хуулийн хэлэлцэхийг бол дэмжиж байгаа. Угаасаа энэ Мэдээллийн ил тод байдал, нийтийн мэдээлэл, хувийн мэдээлэл, энийг дагаж мөрдөх энэ хуулиудыг бид бол цаг алдалгүй, маш чанартай, үр дүнтэй хэрэгжүүлэх, хэлэлцэж батлах ёстой гэсэн байр суурьтай байгаа.

Харин хэлэлцүүлгийн явцад бол бид бас засаж залруулах, сайжруулах юм их байна. Энийг бол нэлээд уншиж үзлээ. Энэ хэдийгээр бид нар одоо нэр нь Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл гэж байгаа. Нийтийн мэдээлэл гэдэг дээр жишээлбэл юуг оруулах вэ? Төрийн байгууллагууд ямар мэдээллийг одоо

нууцлах вэ? Ямрыг нууцлахгүй вэ гэдгийг хэн хаанаа хянах вэ гэдэг асуудал өөрөө бүрхэг байна, нэгдүгээрт.

Хоёрт нь энэ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль маш чухал. Энэ хуулийг цаг алдалгүй гаргах ёстой гээд бид батлаад гаргасан. Өнөөдөр хэрэгжилт нь бол үнэхээр хангалтгүй байна. Тэгээд энэ дээр бас хөндлөнгийн байгууллагуудын хийсэн судалгаа. Энэ тэрээс харахад энийг одоо бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжгүй байна гэж үзсэн гэж байх юм.

Яагаад энийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжгүй байна гэж үзэж байгаа юм. Тэгээд энэ мэдээллүүдийн дор аливаа байгууллага одоо ялангуяа Ковид цар тахалтай холбоотойгоор олон нийтийн мэдэх эрхийг хааж боогдуулсан ийм зүйлүүд нэлээд гараад байна. Зүгээр ганцхан жишээ хэлэхэд бид буруутай, бурууг нь мэдэхгүй гэж мэдэхгүй гээд байгаа юм. Гэхдээ сая тэр Энхсаран сувиллын газар байдал ийм байна гээд мэдэх эрхийг нэг залуу гаргаж тавьсан. Өнөөдөр тэр бол бас буруудаад ингээд шүүгдээд явж байгаа юм билээ. Гэхдээ тэр буруутай буруугүйг би сайн мэдэхгүй. Гэхдээ тэр Энхсаран сувиллын газар бол үнэхээр Ковид цар тахлыг гаргасан, энд хүн Ковидоор өвчлөх нөхцөлийг бүрдүүлсэн гэдэг нь бүх хүний мэдэх эрх байхгүй юу. Тэгж байж хүн өөрийгөө хамгаална.

Тэгэхээр иймэрхүү мэдээллийг одоо жишээ нь юунд оруулах юм. Тэр иймэрхүү бодит байдлыг ил олон нийтэд мэдээлж анхааруулсныхаа төлөө хүн төрийн нууц задаллаа гэдэг шиг байгууллагын нууц задаллаа гээд ингээд буруудаад байх уу? Эсвэл энэ үнэхээр буруутай юу?

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүн нэг минут. Тэгэхээр ямар мэдээллийг бид нар одоо тухайн хүний буруутай олон нийтэд одоо хууль хориотой мэдээллийг задаллаа гэдгийг яаж баталж, мэдэгдэх вэ гэдгийг бид бол тодорхой болгох хэрэгтэй байна. Одоо сүүлд л бас олон нийтийн хэвлэл мэдээллийн зүгээс ч гэсэн хэлээд л байгаа. Улсын онцгой комисс ХӨСҮТ-д болж байгаа явдлыг мэдээлж байж л бусад хүн тэр өвчнөөр өвчлөхгүй байх, эсвэл тэр гажуудал хуулийн завхрал дахин гарахгүй байхын үүднээс мэдээлэх ёстой. Тэгээд мэдээлснийх нь төлөө тухайн албан тушаалтныг юм уу, тухайн эмч сувилагч нарыг хариуцлага цалинг нь хасдаг эсвэл арга хэмжээ авдаг. Тэгээд ийм нэг буруу жишиг тогтох ёсгүй. Тэгээд иймэрхүү зүйл дээр нийгмийг буруутгаад энэ нь өөрөө бас өөр зүйл буруу юм руу турхирах шалтгаан үндэс болоод өгчих вий дээ.

Бид хууль тогтоох дээд байгууллага.

Тийм учраас хуулийг яаж, юу гэж яг ойлгох вэ, тэрнийг хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ, хэн буруутай гэдгийг юугаар яаж тогтоох вэ гэдгийг энэ Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль, энэ Нийтийн эрх мэдээллийн тухай хуулиудаар тодорхой.../минут дуусав/.

Г.Занданшатар: Хишигээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд асуултад хариулна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ Нийтийн мэдээллийн тухай хуулиар бид энэ мэдээлэл авагчийн эрхийг нэг бүлгээр бүтэн хангаж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ хуулийн төслийн 3 дугаар бүлэгт мэдээлэл авах эрхийг хангах гээд. Энд мэдээлэл авах эрхтэй хүмүүс ямар эрхээр хангагдах вэ, мэдээллийг ямар хэлбэрээр авах вэ, ямар тохиолдолд энэ мэдээлэл авагчийн эрхийг хамгаалж өгөх вэ гээд энэ нарийн зохицуулалтыг энэ бүхэл бүтэн

гуравдугаар бүлгээрээ зохицуулж өгч байгаа юм.

Хоёрт гэвэл энэ хууль анх удаагаа ямар мэдээллүүдийг нээлттэй байх вэ гэдгийг бүгдийг нь тоочсон. Түрүүн би танилцуулга дээр дурдсан. Та бүхэн анзаарч сонссон бол. Хүний газар эзэмших эрх ашигт малтмалын лиценз эзэмшиж байгаа тэр мэдээлэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, төрийн болон орон нутгийн өмчит компанийн ашиг орлого, алдагдал, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийнх нь бүтэц, бүрэлдэхүүн гэх мэтчилэнгийн 5 чиглэлийн 67 багц мэдээллийг энэ бол цаашаа нийтэд нээлттэй байх мэдээлэл шүү гэж энэ хуулиар анх удаа ингээд хуульчилж өгч байгаа юм.

Саяын тэр таны ярьсан тэр Энхсарангийн талаарх мэдээллийг цуглуулсан залуу энийг мэдээллийг задалсныхаа төлөө хариуцлага хүлээж байна гээд сошиалаар явж байсан. Яг одоо тэр хэргийн нөхцөл байдлын талаар үзэхэд бол тэр мэдээлэл задалсан гэдэг дээр хариуцлага хүлээж байгаа юм биш юм байна лээ шүү. Шалгуулсан юм байна лээ. Тэр нь юу вэ гэвэл тэр тэнд тогтоосон халдвар хамгааллын журмыг зөрчсөн гэдэг агуулгаар тэр хуулийн байгууллага шалгаж зөрчлийн арга хэмжээ авах авсан гэдэг ийм асуудал яригдаж байна лээ. Тэрнээс биш тэр дотор болж байгаа үйл явдал, процессыг лайв хийж дамжуулсныхаа төлөө ч юм уу, ямар нэгэн байдлаар хуулийн хариуцлага хүлээгээгүй гэдгийг бид нар бас Их Хурлын гишүүд энэ талын нарийн мэдээллүүдийг сонсож байж ярихгүй бол нөгөө сошиалд явж байгаа юм болгон бас үнэн зөв биш юм байна лээ гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Манай зарим одоо сайд, дунд шатны дарга нар ингээд гишүүд бодит юм ярихаар сошиалд хөтлөгдөөд, төрийн бодлого сошиалаар явж байна гээд нэр дэвшээд орж ирж байгаа хүн хүртэл тэгж хэлж байна лээ. Бид сошиалаар ямар ч шийдвэр гаргаж сошиалд автдаггүй ээ. Тэр тусмаа би өөрийнхөө тухай ярихад би хэзээ ч сошиалаар ажил хийдэггүй, шүүмжлэх юмаа яг бодит мэдээлэл дээр үндэслээд шүүмжлээд ярьж байгаа тэр хүн бол Энхсаран сувиллын юмыг задалсан нь бол үнэн шүү дээ. Энхсаран сувилал үнэхээр замбараагүй байсан нь бас үнэн.

Тэгээд Авлигатай тэмцэх газар дээр Энхсаран сувилалд ямар арга хэмжээ авсан нь одоогоор тодорхойгүй байна. Улсын онцгой комисс, ХӨСҮТ дээр болсон явдлууд бол бас бодит үнэн. Яагаад гэвэл бид нар бас ажлын хэсэг. Шалгалт гараад очоод үзэхэд тухайн хүн бодит байдлыг хүргэснээрээ дараа дараагийн ийм алдаа гаргахгүй байх юмыг хийснийхээ төлөө буруудсан зүйлүүд бол байгаа. Яг тэр хүний тухайд ямар үндэслэлээр ямар дүрэм зөрчсөн юм гэдгийг бол би мэдэхгүй. Бид бол сошиалд хөтлөгддөггүй гэдгийг Нямбаатар сайдад хэлье ээ гэж бодож байна.

Яагаад гэвэл бид нар энэ хуулийг гаргахад хүний эрх зөрчигдөхгүй байх, харин хариуцлагыг яг зөв, буруу алдаатай бол тооцдог.../минут дуусав/.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүн үг хэллээ. Одоо цахимаар эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл асуулт асууна.

Баярлалаа.

О.Цогтгэрэл: Энэ Нийтийн мэдээллийн тухай хууль гэдэг хууль орж ирж

байгаад талархаж байна. Хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байгаа. Энэн дээр ганц хоёр хэлэх ёс хэлэх гэж байгаа зүйл нь өнгөрсөн оны төгсгөлөөр Мэдээллийн ил тод мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг бас өргөн барьсан. Энд бас яг л одоо энэ энэ тарьж байгаа төрд суулгаж байгаа Нийтийн мэдээллийг төрийн нууц, хувийн нууцаас бусдыг нь эргэлтэд хэрхэн оруулах тухай. Тэгээд тухайн үед намайг Засгийн газраас санал авч байхад энэ асуудлыг одоо хэлэлцэхгүй, энэ асуудлыг дэмжихгүй гэдэг байр суурьтай Засгийн газрын санал надад ирж байсан. Тэгээд тухайн үед өргөн барьж байсан. Тэгэхээр энэ одоо яагаад бас ийм болчхов. Хамгийн гол нь би болохоор энэ хуулийг одоо орж ирж байгааг маш ихээр дэмжиж байна.

Тэгэхээр миний өргөн барьж байсан хувилбар нэмэлт, өөрчлөлт энд хэрхэн цааш явах вэ, одоо энэ дараа хамтатган хэлэлцэх ёстой юу, аль эсвэл шинэчилсэн найруулга болоод явахлаар зарчмын өөр асуудал гарч байна уу, нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь энэ хуулийн нэрийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль гэдэг энэ тодорхой нэршлийг нийтийн гэж яг өөрчилж байгаа нь яг ямар утга учиртай вэ? Нөгөө хуулийн нэршил бол ерөнхийдөө хүнд бас утга санааг нь шууд илэрхийлж байгаа. Тэгэхээр энэ ямар байдлаар өөрчлөгдсөн юм бол оо?

Дараагийнх нь гуравдугаар асуудал нь болохоор энэ Мэдээлэл авах эрхийг энэ тухай, одоо хүрээнд мэдээллийн үнэлгээг яаж тогтоох гэж байгаа вэ? Төрд цугларсан энэ дата мэдээллийг хэрхэн яаж үнэлэх журам, дүрэм яг ямар байдлаар зохицуулагдах вэ? Ээ хүрээнд хариулт өгөөч.

Г.Занданшатар: Нямбаатар сайд Хишгээгийн Нямбаатар сайд асуултад хариулна.

О.Цогтгэрэл: Би Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ Нийтийн мэдээллийн тухай хууль гэж нэрлэсний шалтгаан нь юу вэ гэхээр энэ мэдээлэл хариуцагч Мэдээлэл эзэмшигч гэдэгт ямар хүнийг ойлгоод байгаа вэ гэвэл нэгдүгээрт төр, түүний одоо бүх бүтцийн байгууллагууд энэ мэдээлэл хариуцагч болж байгаа юм.

Хоёрдугаарт хууль буюу гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагууд бас адилхан мэдээлэл хариуцагч болж байгаа юм.

Гуравдугаарт Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намууд мэдээлэл хариуцагч болж байгаа.

Дараагийн дугаарт төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд энэ мэдээлэл хариуцагч болж байгаа юм. Тэр утгаараа энэ Нийтийн мэдээллийн хууль гэдэг ийм нэршлийг бид нар бас сонгосон. Бидний бас үлгэрлэж байгаа энэ мэдээллийн технологи энэ цахим шилжилтээр их урд явж байгаа улс орнуудын хууль, тогтоомжтой харьцуулсан судалгаа хийсэн. Тэр дундаа Эстонийн хууль дээр бид нар нэлээд ажилласан гэдгийг хэлье.

Эндээс бид нарын нэрийн асуудал гарч ирсэн. Өмнө нь Улсын Их Хурлын гишүүн Учрал бас энэ нийтийн гэж нэрлээд байгаагийн шалтгаан нь юу юм бэ гэхээр бид энэ Байнгын хороон дээр хэлэлцэхэд бас яг л ийм асуудал яригдсан.

Шалтгаан нь мэдээлэл хариуцагч байгаа нь зөвхөн төр биш байгаа юм. Төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нийтийн эрх зүйн бусад субъектүүд байгаа учраас бид нар нийтийн мэдээллийн тухай хууль гэдэг агуулгаар орж ирж байгаа.

Таныг энэ хуулийг яг ийм төстэй нэмэлт, өөрчлөлтийг өргөн барьсныг бид мэдэж байгаа. Энэ бол таны бас тэр дэвшүүлсэн санаа ч их зөв санаа Энэ төрд хадгалагдаж байгаа нээлттэй мэдээллийг эргэлтэд оруулах төлбөртэй, төлбөргүй байдлаар эргэлтэд оруулъя гэдэг. Тэгэхээр энэ хууль дагалдаж одоо бусад гурван хуультайгаа цуг уялдаж гарч ирэх учраас бид нар таны саналыг дэмжээгүй. Засгийн газрын энийг багцаар нь ингэж өргөн барьсан юм.

Мэдээллийн үнэлгээг бол журмаар зохицуулна. Журам гаргана.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Баагаагийн Баттөмөр асуулт асууна.

Б.Баттөмөр: Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл орж ирж байна. Энэ хуулийг одоо хэлэлцэж батлах нь зүйтэй. 2011 онд батлагдаж 11 жил гаруй одоо өнөөдөр үйлчилж байна. Энэ хууль үйлчлэх явц дунд бол бас засах, залруулах нэлээн их олон асуудлууд байгаа нь бол анзаарагдаж байсан. Иргэн хуулийн этгээд нь улсын нууцад хамаарахаас бусад бүх асуудлуудаар мэдээлэл авах ийм эрхтэй гээд заачихсан байгаа юм л даа. Тэгээд энэ хуулийн төсөл маань 2010 онд батлагдсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн үзэл баримтлал 2016 онд батлагдсан Авлигатай тэмцэх хөтөлбөр, Улсын бүртгэлийн хууль гээд энэ бусад хуулиудтайгаа хир зэрэг одоо нийцэж гарч ирж байна гэсэн ийм эхний асуултыг тавьж байна.

Энэ яагаад ингэж тавьж байна гэхээр сүүлийн үед энэ Улсын Их Хуралд орж ирж байгаа хуулийн одоо найруулга, чанар, хамрагдалт шинэчлэл гээд их олон асуудлууд дээр дутуу дулимгүй орж ирж байгаа юм. Жишээ нь бол одоо энэ сая баталсан энэ Хөдөлмөрийн хууль байна. Маш их хэмжээний өөрчлөлт орсон Өршөөлийн хууль байна. Маш их хэмжээний өөрчлөлтүүд орсон.

Тийм учраас энэ хуулийг одоо боловсруулалтдаа энэ бусад хуулиудтай хир зэрэг одоо нийцэж байгаа юм гэсэн ийм асуултыг асуух гэсэн юм. Ил тод байх мэдээллийн зохицуулалт байхгүйгээс зарим төрлийн байгууллагууд нууцад байх шаардлагагүй мэдээллийг нууцад хамруулж Үндсэн хуулиар олгогдсон эрхээ одоо эдэлж чадахгүй одоо байсаар байгаа л даа. Тэгэхээр энийг тэр байгууллага хоорондын уялдаа, хоорондын одоо мэдээлэл солилцох энэ чиглэлд одоо энийг оруулж, ямар зохицуулалтыг хийж байна гэсэн ийм хоёр дахь асуулт байгаа юм.

Төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл харилцан солилцох нь өөрт байгаа мэдээллээс мэдээллийг иргэнээс давхардуулан шаардаж байгаа юм. Энэ бол маш их хүндрэл болдог. Сүүлийн асуулт цахим бичгийн одоо баримт бичгийн үнэн зөв баталгаа.

Г.Занданшатар: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Пүрэвжавын Сайнзориг цахимаар хариулна.

П.Сайнзориг: Сайн байцгаана уу? Та бүгддээ өдрийн мэнд хүргэе Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Сүүлийн асуултаас нь хариулж авъя. Энэ бас хуулийн бас нэг давуу тал нь цаашдаа төрд байгаа мэдээллийг иргэдээс шаардахгүй байх төрд байгаа мэдээллийг төрийн байгууллагууд хоорондоо солилцох энэ бололцоог нийтийн

мэдээллийн дэд бүтцээр дамжуулж хийх гэж байгаа. Мөн нийтийн мэдээллийн дэд бүтцээр одоо гарч байгаа энэ лавлагаа мэдээллүүд ер нь цаашдаа бас дараагийн хэлэлцэгдэх гэж байгаа хууль болох цахим гарын үсгийн хууль байгаа. Цахим гарын үсгээр одоо баталгаажуулсан ийм одоо бичиг баримтуудыг цаашдаа хүлээн зөвшөөрөх, цаасан хувьтайгаа, эх хувьтайгаа ижил тэнцүү байх. Үүнийг нь төрийн байгууллага болоод шүүхийн байгууллага болон хэрэг маргаан хянан шийдвэрлэхэд нотлох баримтаар үнэлэх ийм бололцоог бол бүрдүүлэхэд бас анхаарч байгаа гэдэг зүйлийг хэлье. Мэдээж бас нийтийн мэдээллийн хууль бас хэрэгжээд бас багагүй хугацаа өнгөрсөн.

Энэ хуулийн хэрэгжих тийм үр дагаврыг үнэлгээ хийсэн мэдээж гадаад орны бас тодорхой хуулиудыг харьцуулж судалсан. Энэ хүрээндээ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал хийгээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Улсын бүртгэлийн багц хуультай уялдуулж эдгээр хуулиудыг бас оруулж ирж байгаа гэдэг зүйлийг танд хэлье.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Хассуурийн Ганхуяг асуулт асууна.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд нэгэнт Нийтийн мэдээллийн тухай хууль орж ирж байгаа бол би e.mongolia хариуцсан хүмүүст энэ хаана ямар эмнэлэгт хэдэн ор сул байгаа талаарх мэдээлэл хамгийн түрүүнд оруулаач гэж хүсэх гэсэн юм. Одоо ерөөсөө гадуур эмнэлгийн ор асуусан хүмүүс л их байна.

Тэгээд хэдэн асуулт байна. Нэгдүгээр асуулт болохоор цааш яах вэ одоо цахим засаглалтай холбоотой суурь одоо дөрвөн хууль орж ирлээ л дээ. Тэгэхдээ яах вэ цаашдаа ер нь ямар ямар хууль орж ирэх талаар асуух гэсэн юм. Яагаад гэхээр бид нар цахим засаглалын стратеги гэдэг юм уг нь боловсруулах ёстой байсан л даа.

Магадгүй Цахим бодлогын байнгын хороогоор орж ирэх ёстой байсан байх. Тэр манай Байнгын хороогоор бол энэ цахимтай холбоотой хуулиуд бол орж ирэхээ больсон. Энэ Хууль зүйн яамны Хуулийн байнгын хорооны л асуудал болж байгаа юм шиг байна. Тэгээд цахим стратеги гаргана гэдэг нь бол үндсэн цаашдаа бид нар ямар ямар хууль гаргах юм, дэд бүтэц нь яах юм, тэгээд ямар технологи ашиглах юм, ямар техник ашиглах юм. Зарим оронд энэнээс чинь болж хоорондоо санкц хүртэл тавигдаад явж байгаа.

Нөлөөллийн үнэлгээг хийсэн эсэхийг асуух гэсэн юм. Цахим засаглалын бүтцийг маш тодорхой болгомоор байгаа юм. Одоо яг хэн хариуцах юм. Хууль зүйн яам хариуцах юм уу, эсвэл одоо энэ тэр байгуулагдах гээд байгаа хороо хариуцах юм уу? Аль эсвэл бид нар Мэдээлэл технологийн газар хариуцах гээд байна уу? Асар их хэмжээний одоо энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой асар их хэмжээний, бас төсөв болон дэд бүтэц, технологитой холбоотой асуудал бол гарч ирнэ л дээ. Магадгүй зарим газрууд нь бол энийг хэрэгжүүлэх боломжтой байж болно. Зарим нь бол хэрэгжүүлэх боломжгүй байж болно. Тэрний төсөв мөнгө нь хаанаас гарах хооронд нь уялдаа холбоог нь хангах технологийн асуудлыг нь хаана хэн яаж шийдэх юм, хэн хариуцах юм. Тэгээд иргэд аж ахуйн нэгжүүдийн яг хэрэгцээнд тулгуурласан одоо яг саналыг нь авч байгаад яг ийм ийм мэдээлэл энэ иргэд, аж ахуйн нэгжүүд хүсээд байгаа юм байна гэдэг санал асуулга явуулсан эсэх.

Тэгээд ер нь бол.../минут дуусав/.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн нэмэлт нэг минут.

Х.Ганхуяг: Тэгээд яах вэ цахим гээд хэлчихээр бас юу яагаад байгаа юм л даа. Энэ маш том зөвшилцөл шаардлагатай болно л доо. Зүгээр энгийн аж ахуйн нэгжид ERP суулгахад хүртэл дотроо ажилтнууд хоорондоо үл ойлголцол үүсдэг. Тэгээд энэ аж ахуй одоо энэ байгууллагуудын хооронд бол нэлээн том асуудал бол үүснэ. Энэ хооронд чинь төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага гэх мэтчилэн нэлээн том зөвшилцөл бас шаардлагатай болно. Процессын шаардлагатай шинэчлэх шаардлагатай болно. Энэ бүхнийг хийсний дараагаар одоо нийтдээ энэ манай хэдэн хэмжээний орон тоог одоо цомхотгох боломжтой болох, төр ер нь цомхон болох боломжтой эсэх. Ийм асуултуудаар хариу авах гэсэн юм.

Г.Занданшатар: Мэдээлэл технологийн газрын дарга, Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газрын дарга Даваажавын Болор-Эрдэнэ хариулна.

Д.Болор-Эрдэнэ: Баярлалаа. Улсын Их Хурлын дарга болоод Улсын Их Хурлын гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Хассуурийн Ганхуяг гишүүний асуултуудад хариулъя гэж бодож байна.

Таны эхний саналыг бид нар хүлээж авлаа. Энэ бол маш чухал. Яагаад гэвэл одоо энэ цар тахлын үед бол ямар эмнэлэгт, ямар ор, эмчийн нөөц, эмнэлгийн нөөц байгааг хамгийн түрүүнд бид нар яаралтай энэ хууль маань хэрэгжиж эхлэхээр e.mongolia дээр оруулах нэгдсэн бүтцийн энэ дэд бүтцийнх нь ажлыг хийх нь маш чухал байгаа. Өнөөдөр бол одоо Энхболд сайдаар ахлуулсан ажлын хэсэг яг энэ эрүүл мэндийн салбарын цахимжуулалт дээр ажиллаж байна. Цахим стратегийн талаар ярьсан. Засгийн газрын хэмжээнд бид нар цахим үндэстэн гэдэг ажандааг дэвшүүлээд үүний дагуу Эстонын цахим засаглалын академи болоод бусад улсуудын цахим засаглалын байгууллагуудтай харилцан туршлага солилцоод цахим засаглал, стратегийн ерөнхий зураглалыг бол гаргасан энэ зураглалууд дээр болоод e.mongolia-г хэрэгжүүлж байх явцад бол энэ дөрвөн хуульд заавал батлагдаж байж бид нар энэ цахим шилжилтийн эхний одоо шатыг нь амжилттай давах ийм боломжтой байхаар харагдаж байгаа юм.

Тэгээд энэ дээр түрүүн хэлсэн ялангуяа энэ e.mongolia дээрээс авч байгаа, одоо лавлагаа тодорхойлолт болоод бусад үйлчилгээнүүдийг хуулийн хувьд хүчин төгөлдөр гэж үзэх шүүхийн урд хүчин төгөлдөр гэж үзэх нь өөрөө маш чухал. Төрийн байгууллага хоорондын энэ уялдаа холбоог хангах дээр бол Харилцаа холбоо, мэдээлэл технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газар, Цахим хөгжлийн үндэсний хороо ажиллахаар энэ нийтийн мэдээллийн хууль дээр бол заагдсан байгаа. Нөлөөллийн үнэлгээ болоод бусад одоо судалгаануудыг бол бид нар энэ хуулиудаа дагуулаад хийсэн байгаа.

Г.Занданшатар: Болчихсон уу?

Одоо эрхэм гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг.

Ё.Баатарбилэг: Энэ чухал хууль орж ирж байна. Энэ Мэдээлэл авах эрхийн хууль батлагдсанаас хойш 10 жилийн дараа харин энэ хуулийг оруулж ирж байгаа нь зүйтэй байна. Энэ дотор маш чухал мэдээлэл авах эрхүүдийг бол нээж өгч байна гэж харж байна л даа. Одоо жишээлэхэд манай төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, ялангуяа энэ тендер худалдан авах ажиллагаатай холбоотой

мэдээлэл авах эрхүүд тэр хар жагсаалт энэ тэр гээд л нэг юм байдаг байдаггүй. Тэрэнд нь ямар компаниуд ордог юм гээд л компаниудын эрх ашиг хөндөгдлөө гээд л янз бүрийн юмнууд ярьдаг. Энэ төрийн байгууллагуудын ажлын сул орон тооны асуудлууд байж байдаг. Ингээд нууж байгаад дарж байгаад ах дүү хамаатан саднаа томилдог гэдэг энэ асуудлууд явж байдаг. Тэгэхээр үнэхээр одоо энэ асуудлуудыг үнэхээр цэгцэлж, ингэж энэ хуулиар бүрэн хуульчилж чадаж байвал энэ одоо нэг дэвшил болох гээд байна л даа. Үндсэндээ бол одоо сүүлийн жил жилүүдэд сошиалаар л ажил явуулдаг. Сошиалаар мэдээлэл авдаг болох гээд байна шүү дээ.

Төрийн байгууллагууд сошиал дээр ийм мэдээлэл явж байна гэж байгаа шийдвэрээ өөрчилдөг юм уу. Тэгэхээр ийм байлгахгүйн үүднээс яг энэ албан ёсоор мэдээллээ бодит мэдээллийг төрийн төр засгийн байгууллагууд, иргэдээ бодит мэдээллээр хангах, иргэд нь бодит мэдээлэл авах энэ эрх энэ хуулийн дагуу бүрэн хэрэгжинэ гэж ингэж үзэж байгаа юм.

Би зүгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ганцхан л юм асууя. Энэ одоо ингээд л Их Хурлын гишүүд мэдээлэл авъя гээд л ажлын хэсэгт орлоо, барилаа гээд л мэдээлэл авъя гэхээр тодорхой хэсгийг нь энэ бол нууц гээд л ирүүлдэггүй. Эсвэл нууцын тэмдэгтэй юм ирүүлчхээд энийг та нар гаргаж болохгүй шүү гээд л ингэдэг байхгүй юу. Энэ Эрдэнэс Тавантолгой компанийн төрийн өмчит хувьцаат компанийн одоо жишээлэхэд гэрээ хийж байгаа байдал энэ нүүрсний гэрээ хийж байгаа байдал ч гэдэг юм уу, энэ санхүү үйл ажиллагааны зардлын асуудал жишээлэхэд энэ хуулиар нууцад орох уу, илд орох уу? Одоо бас ингээд нууцаар явж байгаа юм уу? Нийтэд нийт мэдээлэл авах эрх хангагдах уу, үгүй юу энэ дээр.

Яагаад, яагаад энийг.../минут дуусав/.

Г.Занданшатар: Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн нэмэлт нэг минут.

Ё.Баатарбилэг: Яагаад энийг асуугаад байна гэхээр жишээлэхэд, одоо Эрдэнэт үйлдвэр гээд төрийн өмчит компани одоо бүх зарлага, орлого, одоо ашиг орлого юмнууд нь улсын төсөвтөө төвлөрөөд мэдээлэгдээд улсын төсөвтөө дахин хуваарилагдаад. Ингээд явж байдаг. Эрдэнэс Тавантолгой компанийн одоо тэр ашиг орлого гэдэг юм уу юмнууд нь ингээд төсвийн бус маягтай ингээд бид нар ямар ч мэдээлэлгүй ингээд нэг том компани байгаад байдаг. Яг адилхан хоёр компани, тэгээд нэг хэсэг нь болохоор тийм нууцлалтай юм шиг ингээд мэдээлэл нь олддоггүй нэг ийм маягаар яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр яг энүүгээр төрийн өмчит хувьцаат компаниудын, одоо энэ ялангуяа энэ санхүүгийн юмнууд гэрээ, эрх зүй юмнууд нь одоо яг энэ хуулиар иргэдэд нээлттэй болж чадах уу, үгүй юу гэдэг ийм юмыг маш тодорхой жишээн дээр асуугаадахъя.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд асуултад хариулна.

Х.Нямбаатар: Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн ашиг алдагдлын тайлан, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, гишүүд болон гүйцэтгэх удирдлагын овог, нэр авч байгаа цалин хөлс, урамшууллыг ил болгоно гээд энэ хууль дээр заачихсан.

Би бол тантай яг санал нэг байна, энэ Эрдэнэс Тавантолгой гэдэг компанийн яг адил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа бусад компаниудын

гэрээ хэлэлцээр бүх юм ил байдаг. Эднийх бол бүх юмаа хааж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ хуулиараа байгууллага ямар хүрээнд өөрсдөө мэдээллээ нууцлах вэ гэдгээ энэ хуулиар хязгаарыг нь тогтоож өгье гэж байгаа юм. Ер нь бол аливаа юм ил тод байж байж авлига, ашиг сонирхлоос ангид байх нэг боломж бүрдэнэ. Бид нар хоёр асуудлыг шийдэж чадахгүй бол энэ цаашдаа энэ төрийн өмчит компаниудын эргээд л том том авлигын асуудлууд хөндөгдөх байх гэж боддог юм.

Нэг нь юу вэ гэвэл энэ Биржийн тухай хуулиар энэ нүүрс, зэс баяжмалыг борлуулахдаа бид нар үнэ хаялцуулж худалддаг ийм нээлттэй ийм биржтэй болох ийм хууль хэрэгтэй байгаа.

Хоёрт нь юу гэвэл Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр энэ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн эрх зүйн байдлын тухай хууль бичигдээд одоо ингээд дууссан. Өргөн барих одоо бэлтгэлээ хангаад байж байгаа. Энүүгээр ер нь энэ ямар чиглэлээр төрийн өмчит болон орон нутгийн өмчит компани бид нар ажиллуулах юм. Тэр төрийн болон орон нутгийн өмчит компаниуд ямархуу байдлаар гүйцэтгэх удирдлагаа сонгох юм. Улс төрийн хань хамаарлыг нь яаж багасгах юм бэ гэдэг бас ийм суурь хуулийг хийж байгаа юм. Тэгээд энэ ажлын хэсэг дээр та бүхэн бас орж ажиллаад яг саяын мэдээллийг ил тод болгох. Энийг одоо ажлын хэсэг дээр саяын миний хэлсэн заалтыг бүр дэлгэрүүлж болох юм.

Нөгөө байгууллагуудын хориглох мэдээллээ ямар хүрээнд хязгаарлахыг нь хориглож байсан ийм зохицуулалтыг хэдүүлээ энэ боловсруулалтын явцад бас ажлын хэсэг дээр давхар ажиллая л гэж байна. Би таны саналыг дэмжиж байна, Баатарбилэг гишүүн ээ.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин асуулт сууна.

Г.Амартүвшин: Баярлалаа. Энэ хуулийн хэлэлцүүлгийг бол дэмжиж байгаа. Зүгээр нэг ганц хоёр асуулт байна. Одоо жишээлбэл Банкны тухай хуулиар банкны үйлчлүүлэгчдийн аж ахуйн нэгж, хувь хүний мэдээлэл бол нууцлалтай байдаг шүү дээ. Гэтэл сүүлийн үед одоо сошиалаар төлбөр тооцооны мэдээлэл одоо баримтууд нь ил гардаг. Жишээлбэл тэрнээс гадна одоо банк болон аж ахуйн нэгжийн хооронд юм уу хувь хүний хооронд хийсэн хэлцлүүд нь одоо ил гарч ирдэг.

Тэгэхлээр харин ийм мэдээлэл ч бай яалт ч үгүй одоо нээлттэй байх учиргүй гэж бодож байна.

Хоёрдугаарт хэрвээ энэ мэдээллийг задруулсан юм уу. Олон нийтэд нээлттэй болсон тохиолдолд ямар санкц авахаар энэ хуулийн төсөлд тусгасан байгаа вэ. Энэ талаар мэдээлэл өгнө үү?

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Би Амартүвшин гишүүний асуултад маш товчхон хариулъя. Бид нар энэ хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа залгуулаад, цахимын гурван хууль явах юм. Тоон гарын үсэг юуны Кибр аюулгүй байдлын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл явах юм. Энэ дээр бид нар энэ хамгаалалт, хувь хүний нууцыг ер нь цаашид яаж хамгаалах юм бэ гэдэг. Энэ Нийтийн мэдээллийн тухай хуулиар мэдээллийг гурав хувааж байгаа сая би танилцуулгад хэлсэн.

Нэгд нь нээлттэй мэдээлэл, хоёрт нь хязгаарлалттай мэдээлэл, гуравт нь хаалттай, мэдээлэл.

Хаалттай мэдээлэл гэдэг нь төрийн нууцад хамаарах мэдээлэл болон одоо хувь хүний нууцтай холбоотой мэдээллүүд үндсэндээ хаалттай байна. Зүгээр саяхан нэг жишээ татаад хэлэхэд нэг хэрэг дээр тэр залиланг нь нэг их сая нэг айхтар хэрэг гарлаа шүү дээ. Хоёр сая долларыг Худалдаа хөгжлийн банкнаас хүний данснаас өөр итгэмжлэл ашиглаад авчихсан асуудал гарсан. Энэ хэргийг шалгах явцад тэр тухайн хүний дансанд орсон мөнгөний талаарх мэдээллийг банкны эрх бүхий ажилтан орж үзсэн. Ийм лог үүссэн байгаа. Өөрөөр хэлбэл энэ бол маш том одоо тэр хувь хүн дээр хариуцлага тооцох, тэр тухайн ажилд нь хариуцлага тооцох асуудал байхгүй юу.

Тэгэхээр бид нар энэ цахимынхаа 4 хуулиар нэг талдаа ил болгох бүх юмнуудаа ил болгож өгье өө. Энэ хүрээнд одоо бүх мэдээллүүд ил байна. Энэ хүрээн дэх мэдээллүүд бол хязгаартай буюу мэдээлэл эзэмшигчийн өөрийнх нь зөвшөөрлөөр одоо олж авч болдог мэдээллийг эргэлтэд оруулж болох мэдээлэл байна.

Энэ хэсгийн мэдээлэл бол яг тусдаа энэ хаалттай мэдээлэл байна. Хаалттай мэдээлэлд халдвал яах вэ гэдэг маань өөрөө маш том одоо хариуцлага араасаа дагуулах ёстой. Дагуулж энэ хэлэлцүүлгийн шатанд ажлын хэсэг ажиллаад сайжруулалт хийгээд зарим Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалтуудыг ч гэсэн хөндөж хариуцлагыг нь чангаруулъя л гэсэн. Ийм л агуулгаар энэ хуулиудыг цогцоор нь оруулж ирэхийг одоо зорьсон юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Одоо үг хэлэх гишүүн байна уу. Дэмжсэн нь дэмжээгүй гурван гишүүн үг хэлж болно.

Дараа нь санал хураалттай санал хураалтад бэлтгээрэй гишүүд.

Цахимаар нэг гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүнээр хоёр гишүүн Тасаллаа.

Эхлээд эрхэм гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг.

Ё.Баатарбилэг: Хэлэлцэх эсэхийг дэмжиж байна. Энэ цаг үеэ олсон чухал хуулийн төслийг Нямбаатар сайд оруулж ирсэнд талархаж байна. Тэгэхээр энэ 7.1 дээр ерөөсөө нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гээд гурав ангилалд. Тэгээд гурав ангилсан мэдээллээ дотор нь ингээд зүйл заалтаар нь нэлээн нарийвчилсан байна. Би энэ дээр юу гэж хэлэх гээд байгаа юм гэхээр энэ төрийн нэр барьж, тэгээд өөрсдийнхөө хууль бус үйл ажиллагаануудыг эсвэл өөрсдийнхөө эрх ашгийг нууцалдаг энэ байдлыг гаргуулахгүйгээр тэр хаалттай болон хязгаарлалттай мэдээллүүдээрээ зүйл заалтыг нь ахиж сайн нягтлаарай гэж хэлэх гэж байгаа юм.

Одоо Хууль зүйн сайд, ажлын хэсгийнхэн маань одоо энэ нэлээн ажиллах байх. Тэгээд хаалттай мэдээлэл гэхихдэг энд чинь нь тендер сонгон шалгаруулалттай холбоотой юмнууд газар олголт, ажлын байрны сул орон тоонууд тийм ээ, янз бүрийн төрийн байгууллагуудын янз бүрийн мэдээллүүд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ нөгөө энэ гурван ангилал дээрээ яг ямар ямар мэдээллийг хаалттай гэх юм. Яг ямар мэдээллийг хязгаарлалттай гэх юм. Энийгээ л сайн, нэлээн сайн шүүсийг нь шахаж өгөөрэй гэж л хэлэх гээд байгаа

юм. Тодорхой жишээнүүд байгаа шүү дээ. Бид нар энэ Их Хурлын чуулганы хуралдаанууд дээр ч ярьж байсан. Тэгээд өөрсдөө нэг янз бүрийн ашиг сонирхолтой юм уу, янз бүрийн хууль, бусармаг үйл ажиллагаатай холбоотой юмнуудаа хаалттай гэдэг юм руу оруулж хаячхаад. Их Хурлын гишүүн хүртэл үзэхээр нууц гэдэг тэмдэг дарж өгчхөөд. Нууцын гарын үсэг зуруулаад ингээд бид нар олон нийтэд бас шууд мэдээлэл өгч болдоггүй. Эрхээ хязгаарлуулчихдаг. Ийм юм гаргуулахгүй байх. Тэр англи журам юмнууд дээрээ бас ажлын хэсэг дээрээ нэлээн сайн анхаараарай. Би бас энэ хуулийн төслийг нэлээн сайн үзье.

Ажлын хэсэгт бичгээр санал боловсруулж бас хүргүүлэх болно.

Тэгээд хэлэлцэх эсэхийг дэмжиж байна.

Баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Балжиннямын Баярсайхан цахимаар асуулт үг хэлнэ ээ, дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ.

Б.Баярсайхан: Баярлалаа. Энэ хуулийн төслийг хэлэлцэхийг бол дэмжиж байгаа. Маш чухал хууль орж ирж байна. Миний хэлэх үгийг бол сая гишүүд бас хэлж байна. Нэгэнт бид нар цахим улс болно. Эстони улсын Засгийн газартай гэрээ байгуулаад авлигаас ангижрах, төрийн албыг хариуцлагажуулах, төрийн үйлчилгээг цахимжуулах гэсэн одоо ийм том зорилготой явж байгаа. Тэгээд Болор-Эрдэнэ дарга болон энэ IT-гийн чиглэлээр ажиллаж байгаа төрийн байгууллагад одоо бас хэлэх зүйл байна.

Өнөөдрийг хүртэл өөрсдийгөө аваад явж байгаа мэдээллийн технологийн аж ахуйн нэгжүүдтэйгээ одоо хамтарч ажиллаж аль болохоор тэд нарынхаа ажлыг булаалгүйгээр хамтран ажиллах одоо ийм боломж нөхцөлийг гаргаарай. Яагаад гэвэл өнөөдөр бас олон олон мэдээллийн технологийн компаниуд маш одоо олон жилийн хүч хөдөлмөр, олон залуучуудын хүч хөдөлмөрөөр энэ ажлаа хийгээд явж байгаа шүү. Энэ цар тахлын энэ хүнд үед төрдөө түшиг болоод ингээд явж байгаа аж ахуйн нэгжүүд олон байгаа. Бид нар ялангуяа энэ IT-гийн чиглэлээр мэргэшсэн залуучуудаа хөгжилтэй улс орнууд руу маш их алдаж байгаа.

Тийм учраас одоо энэ Монголынхоо энэ салбарыг хөгжүүлэхийн тулд төр, хувийн хэвшил хоёр одоо нягт хамтран ажиллах, бие биеийгээ дэмжих ийм бодлогыг бас барьж ажиллаарай гэж хүсэж байна.

Тэгээд сая гишүүдийн хэлж байгаа энэ и монголиа гээд бид нар одоо нэлээн яриад байгаа яг энэ амьдралд одоо хэрэгцээтэй, яг одоо Ковидын үед бид нар и монголиа -гийн төслийн одоо энэ үр ашиг нь хаана гарч байгаа юм. Энэ иргэд бухимдалтай байгаа мэдээлэл тодорхойгүй байгаагаасаа болж энэ бухимдалтай байгаа. Энэ одоо асуудлууд дээр маш хурдтай ажиллаж энэ цахимжиж байгаа гэдгээ бас иргэдэд бас нэлээн сайн мэдээлж өгмөөр байна. Иргэдийг мэдээллээр хангамаар байна гэсэн ийм саналыг хэлж байна. Тэгээд дараа нь энэ хууль орж ирэхээр тодорхой асуулт асууж, бас санал хэлэх болно. Тэгээд хуулийн төслийг бас дэмжиж байна.

Амжилт хүсье.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Хассуурийн Ганхуяг үг хэлнэ.

Дараа нь санал хураалттай. Гишүүд анхааралтай байгаарай.

Х.Ганхуяг: Хуулийг хэлэлцэхийг бол дэмжиж байгаа юм. Яах вэ, сая Баянгол дүүрэг дээр ЭЕШ-ын дадлага гээд цахим дадлага хийлгэсэн. Одоо багш нараар одоо цахимаар хүүхдүүдийн нөгөө нэг дадлага хийлгэх ажлыг бол зохион байгуулсан. Тэгээд нэг зүйл ажиглагдаж байгаа. Одоо нөгөө хүүхдүүдэд цахимаар хичээлд оролцохыг заахаас гадна багш нарт нь цахимаар хичээл заах тийм шаардлага үүссэн байхгүй юу.

Тэгэхээр нөгөө цахимтай харьцах, нөгөө техник технологио ашиглах тийм сургалт зайлшгүй шаардлагатай байдаг юм байна лээ. Тэгэхээр бид нар чинь одоо 200 гаруй мянган төрийн албан хаагчтай гэдэг. Тэгээд энэ чинь энэ хуулийг хэрэгжүүлээд эхлэхээр бүгдээрээ тодорхой хэмжээнд цахимаар энд оролцох шаардлага үүснэ. Бас багагүй хэмжээний сургалтын зардал гарна. Тэгээд түрүүн би бас төсөвтэй холбоотой асуултууд асуугаад байсан. Тэрэн дээр бол хариу авсангүй л дээ. Тэгээд яг иймэрхүү байдлаар Байнгын хороо нь хариуцах Байнгын хороо нь тодорхойгүй дараа нь хариуцах яг энэ хуулиа хэрэгжүүлэхтэй холбоотой хариуцах эзэн нь тодорхойгүй, төсөв мөнгө нь хаана, яаж гарах нь тодорхойгүй ийм л байгаад байгаа шүү дээ. Тэгээд сургалттай холбоотой асуудлыг зайлшгүй бас тусгаж аваарай л гэж хэл гэсэн юм.

Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 1.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, 2.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, 3.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 4.Улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 5.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, 6.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, 7.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, 8.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, 9.Харилцаа холбооны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, 10.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 11.Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 12.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, 13.Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 14.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 15.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 16.Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Бүртгэлийн санал хураалт явуулна, бүртгэлдээ орцгооно уу.

Туршилтын санал хураалт.

Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 44 гишүүн дэмжиж, 69.8 хувийн саналаар энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь бол дэмжлээ.

Дараагийн асуудалд орно.